



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот


Нийслэлийн өмчид 9 барилга байгууламж
бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1.1 дэх заалт, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Баянгол, Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт тус тус баригдаж, ашиглалтад орсон болон худалдан авсан нийт 43,659,574,824.20 (дөчин гурван тэрбум зургаан зуун тавин есөн сая таван зуун далан дөрвөн мянга найман зуун хорин дөрвөн төгрөг хорин мөнгө) төгрөгийн өртөг бүхий, хавсралтад дурдсан 9 барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 32
дугаар тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ 9 БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУДЫН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Барилга байгууламж ашиглалтад орсон огноо	Төсвийн хөрөнгөөр худалдан авсан огноо	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн өргөтгөлийн барилга	Баянгол дүүргийн 6 дугаар хороо, 10 дугаар хороолол, Номин супермаркет дэлгүүрийн хойд талд	2023.10.10		5,747,288,239.00	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
2	52 дугаар цэцэрлэгийн байр (Инээмсэглэл хотхон 77Б байр, 1 давхрын 181 тоот)	Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо, 15 дугаар хороолол, Эрүүл мэндийн төвийн баруун талд	2020.07.27	2022.12.12	1,292,000,000.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
3	304 дүгээр цэцэрлэгийн барилга байгууламж	Баянзүрх дүүргийн 38 дугаар хороо, Улаанхуарангийн гудамж, Шинэ Амгалан 2-р зэлж хотхоны дунд	2023.11.15		4,279,603,750.00	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
4	321 дүгээр цэцэрлэгийн "А" байр (Сэлбэ хотхоны 97 дугаар байрны 1 давхрын 1, 2 тоот)	Баянзүрх дүүргийн 43 дугаар хороо, 13 дугаар хороолол, Натур худалдааны төвийн урд	2018.02.28	2022.11.14	1,820,000,000.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
5	321 дүгээр цэцэрлэгийн "Б" байр (63 дугаар байрны Б блокийн 1 давхрын В1, В2 тоот)	Баянзүрх дүүргийн 25 дугаар хороо, М.Дамдинсүрэнгийн гудамж, Шинэ Монгол сургуулийн урд	2008.11.28	2022.12.09	1,100,000,000.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
6	Эрдмийн оргил цогцолбор сургуулийн өргөтгөлийн барилга байгууламж	Налайх дүүргийн 8 дугаар хороо, Т.Дамдины гудамж-701 тоот, Цагдаагийн хэлтсийн баруун урд	2023.09.22		7,335,855,327.00	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл
7	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга, байгууламж	Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хороо, Залуус гудамж, Цамбагаравын хойд талд	2022.12.15		8,894,469,088.00	Улсын төсвийн хөрөнгө оруулалт

8	330 дугаар цэцэрлэгийн барилга	Сонгинохайрхан дүүргийн 36 дугаар хороо, Алтан Овооны 37 дугаар гудамжны 16 тоот	2022.10.20	2023.05.01	4,373,882,846.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
9	159 дүгээр сургуулийн барилга байгууламж	Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо, Ногоон талбайн 3 тоот	2023.10.03		8,816,475,574.20	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
	НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН НИЙТ ДҮН					
					43,659,574,824.20	